



JICA ALUMNI MONGOLIA

ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбоо

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бодь цамхаг, 7-р давхар, ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн Газар

Утас: 325 939, 311 329, И-мэйл: jicamg-alumni@jica.go.jp

Цахим хаягууд: www.jaam.mn, <https://www.facebook.com/JICA Alumni Association Mongolia>

ЭНЭ ДУГААРТ

1. ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбоо Бүх гишүүдийн хурлаа амжилттай зохион байгууллаа	1-2
2. 2016 оны “Шилдэг туршлага (Good Practice)-ыг нэвтрүүлэгч”-ээр шалгарсан А.Дэмбэрэлнямбууг танилцуулж байна	2-4
3. Татвар төлөгч болон татварын улсын байцаагчдад зориулсан сургалт боллоо	4
4. “Монгол улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийг 2017-2019 онд хэрэгжүүлнэ	5
5. 2017 оны санхүүгийн жил (2017.04.01-2018.03.31)-д ЖАЙКА-ийн шугамаар Япон улсад зохион байгуулах сургалтын жагсаалт	6
6. Японы эрчим хүчний хэмнэлттэй технологи Зүүн Европын Сербийг өөрчилнө	7
7. Японы уламжлалт цэцэг амилуулах урлаг Икэбана	8
8. Цайны ёслол	8



ЖААМ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЖАЙКА-ИЙН СУРГАЛТ ТӨГСӨГЧДИЙН ХОЛБОО БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛАА АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбооны Бүх гишүүдийн хурал, хүлээн авалт 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдөр Кемпински зочид буудлын “Алтай” танхимд зохион байгуулагдсан бөгөөд хуралд ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын Дарга Сато Мүцүми, ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбооны Тэргүүн Ц.Оюунбаатар

болон Удирдах зөвлөлийн гишүүд нийт 52 хүн оролцлоо.

Хурлын үеэр тус холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Т.Золбоот холбооны 2016 оны санхүүгийн жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан болон 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар танилцууллаа.

Мөн, хөтөлбөрийн дагуу өөрсдийн сурч мэдсэнээ бусадтай хуваалцаж, ажил үүрэгтээ нэвтрүүлэн хэрэгжүүлсэн шилдэг төгсөгчидөө шалгарууллаа. 2016 оны “Шилдэг туршлагыг нэвтрүүлэгч”-ээр Завхан аймгийн Б.Элдэв-Очирын нэрэмжит



I сургуулийн биологийн багш С.Алтанзул, Нийслэлийн Тээврийн газрын Орлогч дарга Х.Булгаа, СУИС-ийн Соёлын сургуулийн Соёл судлалын тэнхимийн эрхлэгч Ж.Мяндас нар шалгарлаа.



Чандмань-Эрдэнэ лаборатори сургуулийн суурь боловсрол хариуцсан сургалтын менежер А.Дэмбэрэлнямбуу, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Үндэсний лаборатори



Энэ жилийн хурлын хөтөлбөрт Төгсөгчдийн зургийн үзэсгэлэн, шанз хөгжмийн тоглолт, Кэндогийн үзүүлбэр, сугалаа зэргийг оруулсан нь урьд жилүүдийн хурлуудаас өвөрмөц байлаа.

2016 ОНЫ ШИЛДЭГ ТУРШЛАГА (GOOD PRACTICE)-ЫГ НЭВТРҮҮЛЭГЧЭЭР ШАЛГАРСАН А. ДЭМБЭРЭЛНЯМБУУГ ТАНИЛЦУУЛЖ БАЙНА

Одоогийн албан тушаал: Завхан аймаг Б.Элдэв-Очирын нэрэмжит Чандмань-Эрдэнэ лаборатори сургуулийн суурь боловсрол хариуцсан сургалтын менежер, Монгол улсын гавъяат багш, Монгол улсын зөвлөх багш

А.Дэмбэрэлнямбуу 2011 онд Япон улсад “Хичээлийн судалгааны арга зүй, менежмент” сэдэвт сургалтанд оролцож мэдлэг, мэргэжлээ дээшлүүлсэн бөгөөд түүнийгээ ажил үйлс нэгт багш нартайгаа хэрхэн хуваалцаж, сургалтын практикт хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн туршлагаас нь Та бүхэнд хүргэж байна.

Сургалтаар эзэмшсэн мэдлэг: Энэхүү сургалтанд оролцсоноор Япон улсын түүх, ард түмний соёл, ёс заншил, боловсролын тогтолцоо, ерөнхий боловсролын дунд сургуулиудын туршлага, сургалтын агуулга, хичээлийн

технологи, багш, сурагчдын харьцаа, хичээлийн судалгааны мөн чанар, үе шатууд, ач холбогдлын талаар шинэ мэдлэг эзэмшсэн. Мөн эзэмшсэн мэдлэгээ өөрийн улс орон, орон нутаг, сургуулийнхаа түвшинд хэрхэн хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлэх аргад суралцсан.

Мэдлэгээ бусад түгээн дэлгэрүүлсэн туршлага:

➤ Төр, засгийн бодлого, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн тохирцыг судлан тогтоох, турших, хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх ажлыг өөрийн сургууль

төдийгүй Завхан аймгийн ЕБС-иудад түгээн дэлгэрүүлэх ажилд манлайлан оролцсон.

- Өөрийн аймгийн 6 бүсийн 29 сургууль төдийгүй, баруун бүсийн \тухайлбал Баян-Өлгий аймаг\ аймгуудын сургуулиудын үйл ажиллагаа, хичээлийн судалгааны хэрэгжилтэнд мониторинг хийх багт орж ажилласан.
- ЖАЙКА-гийн төслийн Удирдлага менежментийн багийн аймгийн болон бүсийн сургагч багшаар ажилласан.
- Сургуулийн “Хичээлийн судалгааны баг”-ийг удирдан ажиллахын тулд аймгийн болон үндэсний сургагч багш нар, япон багш нартай хамтран ажилласан.
- Хичээлийн бэлтгэл судалгаа, ажиглалт, хэлэлцүүлэг, сайжруулсан хөтөлбөр боловсруулах зэрэг хичээлийн судалгааны үе шат бүрд биечлэн оролцож, багш нарт тухайн хичээлд судалгааны үндэстэй хандах, хичээлийн судалгааны арга зүйг эзэмшүүлсэн.
- Японы хичээлийн судалгааны видео хичээлүүдийг өөрийн болон бүсийн сургуулиудын багш нарын хичээлийн судалгааны үйл явц, үр дүнтэй харьцуулалт, дүн шинжилгээ хийж, алдаа дутагдлуудаа арилгаж, амжилт ололтуудаа багатган ажилласан.
- Сурагчдынхаа хичээлийн судалгааны үйл ажиллагааны үр дүнд гарсан хөгжлийн өөрчлөлтийн судалгаа, багшлахуйн арга зүйн өөрчлөлтийн судалгааг жил бүр хийж, ололттой тал, сул тал,тулгамдаж буй асуудал, бэрхшээл, даван туулах арга замыг тодорхойлж ажилласан.
- ЕБС-д “Хичээлийн судалгаа” хийх менежмент ба эрх зүйн холбоог судалж хэрэгжүүлсэн.
- Хичээлийн судалгаа, суралцахуйд суурилсан багшлах арга зүйн чиглэлээр хийсэн судалгаа, хуримтлуулсан туршлагын илтгэлийг бүс, аймаг, улсын хэмжээнд удаа дараа хэлэлцүүлж, гарсан санал бодол, сайшаал урамшуулал, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.
- Хичээлийн судалгааны явц байдал, хэрэгжилтийн талаар нийслэл дүүрэг болон аймаг орон нутгийн загвар сургуулиудын тайлангийн зөвлөгөөнд 3 удаа илтгэл тавин хэлэлцүүлж, япон багш нар болон үндэсний сургагч багш нараас үнэлэлт, дүгнэлт, зөвлөгөө авч ажилласан.
- Өөрийн сургуулийн оюуны бренд болох “Хичээлийн судалгааны загвар, туршлага”- ыг бий болгож, бусдад сурталчилсан.
- Завхан, Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай аймгийн ЕБС-иудын 1632 багш, удирдах ажилтанд 15 удаа сургалт зохион байгуулж сурч мэдсэнээ бусдад түгээн дэлгэрүүлсэн.

Бусадтай хуваалцсан мэдлэг, туршлагын үр дүн:

Япон улсад “Хичээлийн судалгааны арга зүй” сургалтанд оролцож эзэмшсэн мэдлэг, өөрийн бодит үйл ажиллагаандаа хуримтлуулсан туршлагаа бусадтай хуваалцан ажилласанаар дараах үр дүнгүүдэд хүрсэн юм.

- Багш нарын хувийн чадварын түвшинд:

- Хичээлийн судалгааны арга зүйг эзэмшсэн.
- Хичээлд ажиглалт хийж сурсан.
- Хэлэлцүүлэг хөтөлж сурсан.
- Бусдын хичээлд үнэлэлт, дүгнэлт өгч сурсан.
- Алдааны шинжилгээ хийж сурсан.
- Асуулт төлөвлөх аргад суралцсан.
- Суралцагчдын ялгаатай байдлыг мэдэрч, ялгаатай дэмжлэг үзүүлэх аргад суралцсан.
- Самбарын төлөвлөлт, бичиглэлийг хийж сурсан.
- Багаар ажиллах чадвар сайжирсан.
- Багш ажлын байрандаа хөгжих хичээлийн судалгааны аргад чамбай суралцаж, бусдад түгээн дэлгэрүүлж чаддаг болсон.

Сургууль хамт олны түвшинд:

- Манай сургууль Японы ОУБ ЖАЙКА, БСШУЯ-ны хамтран хэрэгжүүлсэн “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төслийн загвар сургуулиар сонгогдон 2010-2013 он хүртэл 3 жил төслийг амжилттай хэрэгжүүлсэн.
- Японы сургуулиудад багш нарынхаа ур чадвар, арга зүйг хэрхэн сайжруулж байгаа болон сургуульд суурилсан хичээлийн судалгаатай танилцаж, тэднээс суралцсанаар сургуулийн удирдлагын менежментийг өөрчлөн сайжруулж сургуульд суурилсан хичээлийн судалгааг багшийн үндсэн үйл ажиллагаагаа болгон хөгжүүлснээр хүн бүр ажлын байран дээрээ хөгжиж чадсан.
- Багш ажлын байран дээрээ хөгжих, арга зүйн чадамжаа дээшлүүлэх сонгодог арга хэлбэр болох “хичээлийн судалгааг” хийж сурснаар багш нарын хандлага, хичээл заах арга зүйд эрс өөрчлөлт, ахиц дэвшил гарсан.
- Хичээлийн судалгааны арга зүйн туршлага хуримтлуулах, хичээлийн судалгааны илтгэл бичих аргад нэлээд сайн суралцаж, энэ судалгааны ажилдаа олон залуу багш нарыг суралцуулж энэхүү судалгаа шинжилгээний ажлынх нь туршлагыг багш нар нь өвлөн авч, эрдэм шинжилгээний илтгэл бичих арга зүйд суралцан улсын хэмжээний шилдэг илтгэлийн уралдаанд оролцож удаа дараа тэргүүн байранд шалгарсан.
- Залуу багш нар аймаг, улсын хэмжээний шилдэг, тэргүүний арга зүйчид болсон юм. Тухайлбал: Улсын ур чадварын уралдаанаас 3 багш 90-ээс дээш хувийн үнэлгээтэй шалгарч, Завхан аймгаас “Монгол улсын оны шилдэг” 4 багш төрсөний 3 нь тус сургуулийн суурь боловсролын багш нар байна.
- Хичээлийн судалгааны арга зүйн туршлага хуримтлуулж, БМДИ, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгээс хамтран сүүлийн 4 жил зохион байгуулж байгаа Үндэсний эрдэм шинжилгээний онол практикийн бага хуралд өөрийн үндсэн мэргэжлээрээ химийн судлагдахууны багш нартай хамтарсан илтгэл бичиж хэлэлцүүлснээс цахим номонд орох эрх (2015 он), мөн Япон улсад аялах,

үндэсний технологийн санд байршуулах эрх (2016 он)-ээр тус тус шагнагдсан.

- Сүүлийн 4 жилийн хугацаанд 58 багшийн хамтын бүтээл 21 илтгэл үндэсний түвшинд хэлэлцэгдэж, Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгээс зохион байгуулдаг үндэсний эрдэм шинжилгээний III, IV бага хуралд (2015, 2016 он) хэлэлцүүлсэн багийн хамтын илтгэлүүд Үндэсний



технологийн санд бүртгэгдэн Япон улсад аялах эрхээр шагнагдаж, 6 багшийн илтгэл цахим номонд, 4 багшийн илтгэл шилдэгийн шилдэг бүтээлүүдийн эмхтгэлд нийтлэгдсэн.

- Тус сургууль нь Завхан аймгаас үндэсний хэмжээний лаборатори сургуулиар сонгогдсон нь ЖАЙКА-гийн БАЗХТДТБ төслийн загвар сургуулиар сонгогдож уг төслийг амжилттай туршин хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлсний бодит үр дүн юм.



ТАТВАР ТӨЛӨГЧ БОЛОН ТАТВАРЫН УЛСЫН БАЙЦААГЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ БОЛЛОО

2017 оны 3 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон хөнгөлөлт чөлөөлөлтийн тайланг хэрхэн гаргах, хувь хүний орлогын тайланг хэрхэн гаргах талаар, мөн “Төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын туршлага” сэдэвт сургалтыг Баянзүрх дүүргийн Татварын хэлтэстэй харилцдаг 279 татвар төлөгчдөд зориулан ЖАЙКА-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр амжилттай зохион байгуулж ажиллаа. Тус сургалтыг БЗД-ийн Татварын хэлтсийн Татварын улсын байцаагч Ц.Эрдэнэхүү, Д.Үнэнчимэг, тус холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Я.Аюушжав, ЖАЙКА-ийн сургалт төгсөгч Татварын улсын байцаагч К.Еркегүл нар зохион байгууллаа.



Семинарт нийт 452 татвар төлөгч болон татварын байцаагчид хамрагдсан ба уг сургалт нь сургалтын хөтөлбөр, гарын авлага тараах материалаар хангагдсан, татвар төлөгч болон татварын байцаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлсэн маш

үр дүнтэй сурах, мэдэхийг урьтал болгосон чухал сургалт боллоо. Татвар төлөгч татварын тайлан гаргах болохоор заавал мэргэжлийн нягтлан хайж цаг хугацаа, хөрөнгө мөнгө зардаг байсан бол энэ сургалтанд сууснаар бизнес эрхлэгч бүр өөрийн орлого зардлаа тооцож тайлангаа гаргаж сурсан нь сургалтын гол зорилго байсан юм.

“МОНГОЛ УЛСЫН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ”-ИЙГ 2017-2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛНЭ

Онцгой байдлын ерөнхий газар, ЖАЙКА-тай хамтран “Монгол улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийг 2017-2019 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэхүү төслийн Хамтарсан зохицуулах хорооны хоёрдугаар хурал 2017 оны 4 дүгээр сарын 14-нд ОБЕГ-т боллоо. Хурлын нээлтийн арга хэмжээнд ОБЕГ-ын дарга, бригадын генерал Т.Бадрал,



нийслэлийн Засаг даргын орлогч П.Баярхүү, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга Сато Мүцүми нар болон төслийн багийн гишүүд, ОБЕГ, НОБГ, БХБЯ, БСШУСЯ-наас холбогдох удирдлага, албан тушаалтнууд оролцлоо. Мөн 2017 онд Монгол улсын гамшгаас хамгаалах тухай хууль шинэчлэгдэн батлагдсан бөгөөд уг хуульд болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар тодорхой заалтууд тусгагдсан. Энэхүү



хуультай холбогдуулан нэлээдгүй дүрэм, журам, зааврыг шинээр болон шинэчлэн боловсруулах шаардлага гарч байгаа юм.

Уг төслийн хүрээнд 2017 оны 3 дугаар сарын 20-ноос 29-ний хооронд Шадар сайдын ажлын алба, БХБЯ, БСШУСЯ, ОБЕГ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын төлөөлөл



багтсан нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй баг Япон улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлаад ирсэн билээ. Энэ хүрээнд Японы тэргүүн туршлагаас суралцан монголын хөрсөнд буулган газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, орчин үеийн техник, технологи нэвтрүүлэхэд төслийн баг гол анхаарлаа хандуулан ажиллах шаардлагатай байгаа юм.



2017 ОНЫ САНХҮҮГИЙН ЖИЛ (2017.04.01-2018.03.31)-Д ЖАЙКА-ИЙН ШУГАМААР ЯПОН УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ЖАГСААЛТ

№	Course title	Training Period from	Training Period until
1	Remote Sensing of Forest Resources	17.05.07	17.06.24
2	International Taxation for Asian Countries	17.05.08	17.05.30
3	Power Distribution Grid(B)	17.05.11	17.06.07
4	Business management of agri-business for CIS and Mongolia	17.05.14	17.05.27
5	Sustainable use of wetland resources for local benefit	17.05.16	17.07.08
6	Managerial and Financial Support for Small and Medium Enterprises Development(A)	17.05.22	17.06.24
7	The Land Readjustment Method for Urban Development	17.05.24	17.07.16
8	Energy Policy(A)	17.05.31	17.06.30
9	Improvement of Education in Remote Areas - For the Achievement of SDGs(A)	17.06.07	17.06.24
10	Executive Program in Public Finance Management / Government Debt Management	17.05.17	17.06.03
11	Improving Teaching Methods for Science and Mathematics in Primary Education(A)	17.05.30	17.07.21
12	Rural Development through creating Agricultural Value Chain (Value addition to Agricultural and Livestock Products)	17.06.20	17.08.26
13	Roles of Regulatory System and Pharmacists on Ensuring Proper Access to Quality Assured Medicines	17.06.28	17.08.02
14	Improvement of accessibility for social inclusion - Barrier-free environment for all -	17.07.02	17.07.29
15	Renewable Energy in Grid -Mainly on Photovoltaic-(A)	17.07.02	17.08.11
16	Capacity Building towards Air Quality Management	17.07.05	17.08.10
17	Strengthening of Business Development Services (BDS) for industrial promotion(A)	17.07.12	17.08.12
18	Public Participation, Consensus Building and Resettlement in Public Works Project	17.07.30	17.08.31
19	PBN Instrument Flight Procedure Design	17.07.30	17.09.16
20	Competition Law and Policy -Laying the Foundation for Investment Promotion-	17.08.13	17.09.02
21	Financial Regulation and Supervision	17.08.13	17.08.23
22	Operation and Maintenance of Sewerage System(C)	17.08.20	17.10.04
23	Improvement of Maintenance Skills for Gas Turbine and Coal Fired Steam Turbine Power Engineering(B)	17.08.23	17.10.20
24	Social Participation and Livelihood of Persons with Disabilities through a Community-Based Inclusive Approach(B)	17.08.23	17.09.16
25	The total planning of airport construction, management and maintenance	17.08.27	17.10.07
26	Road Maintenance(B)	17.08.30	17.10.07
27	International Seminar on Taxation (General)	17.09.03	17.10.07
28	Comprehensive Approach for Improvement in the Quality of Learning	17.09.03	17.09.27
29	Comprehensive City Planning	17.09.04	17.10.28
30	Fire Management and Disaster Risk Reduction	17.09.05	17.11.25
31	Strengthening Safety Management System of Agricultural Products(A)	17.09.24	17.10.14
32	Food Safety Administration	17.09.30	17.11.01
33	Stock Exchange Development in Asian Countries(A)	17.10.01	17.11.10
34	Regional Industry Promotion by Cluster Approach(A)	17.10.01	17.10.31
35	Metal-Mining Development Administration	17.10.01	17.10.28
36	Executive Seminar for Grid Operators	17.10.04	17.10.28
37	Water Supply Administration for Better Management of Water Supply Services(Joint Program with Japanese Water Utilities' Capacity Enhancement Training)(B)	17.10.04	17.10.21
38	General Management for Regional Development and Planning	17.10.09	17.11.25
39	Civil Aviation Safety Oversight	17.10.15	17.10.31
40	Adaptation to Climate Change	17.10.15	17.11.11
41	Development of Agricultural Cooperatives and Improvement of Management Capacity(B)	17.10.15	17.11.18
42	Comprehensive countermeasure for viral hepatitis	17.10.17	17.11.12
43	Quality Improvement of Primary Science Education ("Teaching and Learning" at on-site education)	17.10.22	17.12.16
44	Program for the Specialist of Healthcare-Associated Infection Control and Prevention(B)	17.10.24	17.11.18
45	Planning the lessons for children with disabilities in the context of special needs education (SNE)	17.10.29	17.11.25
46	Education System for Children with Disability -Promotion of Inclusive Education System utilizing the experience of Special Needs Education-	17.10.29	17.12.05
47	Promotion of Mainstreaming Disaster Risk Reduction	17.11.05	17.11.18
48	National and Regional Development Policy	17.11.05	17.12.21
49	Branding and Marketing of Products utilizing local resources(A)	17.11.22	17.12.16
50	Local Industry Development in Agricultural Regions by Strengthening Capacity of Management and Marketing(B)	18.01.08	18.02.10
51	Seminar on Aviation Security	18.01.17	18.02.23
52	International Criminal Investigation	18.01.21	18.02.10
53	Small and Medium Enterprise Development Policies(C)	18.01.30	18.02.20
54	Collection, Analysis and Dissemination of Data regarding Solid Waste Management	18.02.18	18.03.03
55	Research on Veterinary Technology	18.03.25	18.10.27
56	Comprehensive Regional Development Planning Course	17.08.01	17.08.31

Дээрх сургалтуудтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг 325939, 311329 утсаар Сургалт хариуцсан ажилтан Э.Саранзаяатай холбогдож тодруулна уу.

ЯПОНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ТЕХНОЛОГИ ЗҮҮН ЕВРОПЫН СЕРБИЙГ ӨӨРЧИЛНӨ



Сербийн нийслэл Белград

Япон бол эрчим хүчийг дэлхийд хамгийн үр ашигтай, хэмнэлттэй хэрэглэдэг орон билээ. Японы эрчим хүч хэмнэх дэвшилтэт технологийг суралцахаар анх 2005 онд ЖАЙКА-ийн сургалтаар Японд очсон Белградын их сургуулийн Механик инженерийн факультетийн судалгааны ажилтан Милица өөрийн эх оронд энэхүү шинэ технологийг нэвтрүүлэх шаардлагатай гэдгийг ойлгожээ. Тэрээр эх орондоо буцаж ирээд Япон маягийн эрчим хүчний хэмнэлттэй технологийн онцлог болох Qualified Person for Energy Management* тогтолцоог өөрийн улсдаа нэвтрүүлэх хүсэлтээ ЖАЙКА-ийн Балкан дахь төлөөлөгчийн газарт гаргажээ.



Илтгэл тавьж буй Милица

Улмаар ЖАЙКА Милицагийн хүсэлтийг хүлээн авч Сербийн Засгийн газартай хамтран 2009 оноос Qualified Person for Energy Management тогтолцоог нэвтрүүлэх судалгааны ажлаа эхлүүлсэн байна. Судалгааны үр дүнд Серби болон Японы үйлдвэрт чанарын шаардлага хангасан нэг төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тохиолдолд Сербид Японоос 4 дахин их эрчим хүч зарцуулж байгаа зэргээр энэхүү тогтолцооны олон талт давуу талууд илэрхий болсон байна. Уг судалгааны үр дүнд үндэслэн 2013 оны 3 дугаар сард Сербийн Засгийн газар “Эрчим хүчний үр ашигтай хэрэглээний тухай хууль” батлах зэргээр Япон маягийн эрчим хүчний хэмнэлттэй технологийг нэвтрүүлэх болжээ. Улмаар ЖАЙКА-ийн зүгээс 2014 оноос “Эрчим хүчний салбар дахь хяналтын тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж, эрчим хүчний менежментийн мэргэжилтэн, оношилгооны мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн байна. Мөн 2016 оны 10 дугаар сараас Белградын их сургууль дээр эрчим хүчний менежментийн мэргэжилтэн, оношилгооны мэргэжилтэн бэлтгэх тусгай анги шинээр байгуулагдсан байна.

** Qualified Person for Energy Management: Эрчим хүчийг үр ашигтай зарцуулахын тулд эрчим хүч зарцуулдаг тоног төхөөрөмжний засвар үйлчилгээ болон эрчим хүчний хэрэглээг сайжруулах, хянах, мөн Эдийн засаг, аж үйлдвэрийн яамны тушаалаар батлагдсан аливаа ажилд хяналт тавьдаг мэргэжилтэн.*



ЯПОНЫ УЛАМЖЛАЛТ ЦЭЦЭГ АМИЛУУЛАХ УРЛАГ ИКЭБАНА

Икэбана нь Японы уламжлалт урлаг бөгөөд амьд ургамлын навч, цэцэг зэргийг өнгө алаглуулан, харахад үзэмжтэйгээр зохицуулан байршуулдаг урлаг юм. Икэбана нь цэцгээр өргөл өргөдөг байсан Буддын шашины эртний соёлоос улбаатай бөгөөд дотроо олон урсгалуудтай, урсгал тус бүр нь өөр өөрийн гэсэн онцлогтой байдаг.

Икэбана нь өргөн мэдлэг, маш нарийн мэдрэмж шаардахаас гадна амьдралын учир утгыг мэдрүүлж, байгалийн гоо сайхныг таашаах сэтгэгдэл төрүүлдэг. Энэхүү урлалыг гүйцэтгэхийн тулд түүний материал сав, мөчир, дэлбээ нэг бүрийн байршил, мөчирнүүд нь савандаа, мөн орчин тойрныхоо зүйлстэй хэрхэн зохицож байгааг дээд зэргээр анхааран донжийг нь тааруулдаг бөгөөд хүнийг гоо зүйн мэдрэмжтэй болгох, мөн цэцэгнээс маш олон төрлийн таатай мэдрэмжийг хүлээж авах боломжтой болгодог.



ЦАЙНЫ ЁСЛОЛ

Япончууд цайны ёслолыг урлаг болгон хөгжүүлж чадсан байдаг. Цайны ёслол гэдэг нь Япон үндэсний ёс заншлын дагуу цай чанаж зочин гийчнээ дайлах урлаг юм. Цайны ёслолд хэрэглэдэг идээ нь маш нунтаг байдаг. Түүнийг аяганд хийж дээрээс нь буцалсан ус нэмээд зориулалтын сойз хэлбэртэй зүйлээр хутган, хөөсрүүлэхэд ногоон өнгөтэй Япон цай болдог. Түүний амт нь маш өвөрмөц төдийгүй цайг уухаасаа өмнө чихэрлэг зүйл идвэл гашуун амт нь дарагддаг. Цайны ёслолын явцад олон янзын үйл хөдлөл, баримтлах ёс байдаг. Япон ногоон цай нь эрүүл мэндэд ихээхэн ач тустайгаас гадна жин хасах, хөгшрөлтийг удаашруулдаг зэрэг олон давуу талуудтай байдаг.

